

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2023.01.13

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 5, 7 дугаар зүйл, Залуучуудын хөгжлийн зөвлөлийн 2021 оны тогтоол, Соёлын сайдын 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/85 дугаар тушаал, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 3/1298 тоот, Соёлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 6/866 тоот албан бичгийн дагуу Дархан-Уул аймгийн Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөл нь 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр 25 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан.

Залуучуудын хөгжил оролцоог дэмжих, эрхийг хангах, салбар хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачлагыг дэмжих замаар залуучуудын үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилготой тус орон тооны бус Зөвлөлийн даргаар аймгийн Соёл, урлагийн газрын Урлаг, уран бүтээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Отгонбаяр сонгогдон ажиллав.



Тус зөвлөл нь Залуучуудын хөгжлийн зөвлөлийн дүрмийг зохион байгуулалт, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Тайлант хугацаанд 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Соёлын бүтээлч үйлвэрлэлийн 12 салбарын залуучуудын хөгжлийн 14 салбарын төлөөлөл Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд Ч.Номинтой уулзалт хийхэд тус аймгаас салбар зөвлөлийн дарга Ц.Отгонбаяр төлөөлөн оролцлоо.



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2023.01.13

№	Ажлын нэр	Хугацаа	Хамтран зохион байгуулагч	Тайлбар
1	Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлийн хурал	I улирал	Соёл, урлагийн газар, Соёлын байгууллагууд	Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулна. Оны ажлын төлөвлөгөөг батлана.
2	Уран зургийн үзэсгэлэн	I улирал	Дарханы Зураач, урчуудын эвлэл	Хамтын ажиллагаа сайжирна.
3	“Өв соёлоо өвлөн уламжлагч” сургалт	II улирал	Дархан-Уул аймгийн Гар урлалын холбоо	Хамтын ажиллагаа сайжирна
4	“Хаврын баяр” бүжгийн наадам	III улирал	Дархан-Уул аймгийн бүжгийн холбоо	Хамтын ажиллагаа сайжирна.
5	Залуучуудын хөгжлийн сарын хүрээнд “Соёлын салбар дахь залуучуудын оролцоо” хэлэлцүүлэг	III улирал 8 дугаар сарын 12 - “Олон улсын залуучуудын өдөр”, 8 дугаар сарын 25 - “Монголын Залуучуудын өдөр”	Соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Залуучуудын асуудалд анхаарлаа хандуулж залууст ээлтэй шийдвэр гарган ажиллахыг шийдвэр гаргагчдад уриална.
6	Сан байгуулах	Жилийн турш	D- art продакшн, Дархан-Уул аймгийн Дуучдын зөвлөл	Сан байгуулахад шаардлагатай ажлуудыг үе шаттай хийнэ.
7	“Залуусын хот” эвэнт	III улирал	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Соёл, урлагийн газар, Залуучууд театр, D- art продакшн, Дархан-Уул аймгийн Дуучдын зөвлөл, чөлөөт уран бүтээлчид зэрэг	Хотын уламжлалт соёлын арга хэмжээ болгоно.

Дархан-Уул аймгийн Соёлын салбарын залуучуудын
хөгжлийн зөвлөл